МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

MONES

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

MONGOLIAN WOMEN'S FUND

# 2010 ANNUAL REPORT
# жилийн тайлан

НИЙГМИЙН ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮЧИРХЭГЖҮҮЛНЭ

EMPOWERING WOMEN FOR SOCIAL JUSTICE

# МЭНДЧИЛГЭЭ

***Эрхэм хүндэт анд найзууд аа,***

2010 он МОНЭС-ийн түүхэнд дурсагдан үлдэх сайхан жил болж өнгөрлөө. Бид үүсэн байгуулагдсаныхаа 10 жилийн ойг тэтгэлэг авагч бүлгүүд, хандивлагчид эгч дүү олон улсын сангийнхан, хамтрагчид, сайн дурынхантайгаа тэмдэглэн өнгөрүүллээ.

Энэ үеэр ОУ-ын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээний /ЭСС/ ээлжит уулзалт манай орноо болж дэлхийн 32 эмэгтэйчүүдийн сангийн 42 төлөөлөгчид эх оронд минь морилон саатлаа. Энэ нь Монголын эмэгтэйчүүдийн хөгжил, дэвшилтэй танилцах, бусадтайгаа ололт амжилтаа хуваалцах сайхан боломж олдсон төдийгүй бидэнд урам зориг өгсөн үйл явдал болсон юм.

Бид 10 жилийн туршид Монголын эмэгтэйчүүдийн хөгжилд оруулсан хувь нэмрээ үнэллээ. Өөрсдийн сул ба давуу талаа тодорхойлж, тэтгэлэгийн стратеги чиглэлийг хяналаа. Манай байгууллага 10 жилийн турш тогтвортой ажиллаж охид, эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөө, хөгжил дэвшил, нийгмийн өөрчлөлтийн төлөө өөрийн хувь нэмрээ оруулсан сайхан түүхийг бүтээсэндээ баяртай байна.

МОНЭС тэтгэлэг олгох хөтөлбөрийнхөө стратеги чиглэлийг баримталж мянга мянган хүчирхэг эмэгтэйчүүдийг бий болгож нийгмийг өөрчлөхийн төлөө зорьж ажиллаж байна.

МОНЭС сонгон ажиллаж байгаа бүсийн аймгуудын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаар хөгжүүлэхийг дэмжлээ. Улаанбаатар төдийгүй тухайн бүс нутгийн аймгуудын эмэгтэйчүүдийн ТББ-д хоорондоо суралцах аялал болон бүсийн уулзалтуудыг зохион байгуулж байна. Ингэснээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын чадавхи богино хугацаанд нэмэгдэж байгаа төдийгүй түншлэл хөгжиж, эмэгтэйчүүдийн амьдралд өөрчлөлт авчрах боломжийг олгож байна.

Мөн эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар нэгдэн ажиллаж байгаа сүлжээ, холбоо эвслийн хамтын ажиллагаа,түншлэлийг хөгжүүлэх бодлогоо үргэлжлүүлэн баримталж байна.

2011 он бол сонгуулийн өмнөх жил учраас орон нутгийн эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэхийн төлөө илүү анхаарч хөрөнгө нөөцийг хуримтлуулан ЭТББ-уудын тогтвортой байдалд анхааран ажиллана.

МОНЭС-ийн эрхэм дотны нөхдөдөө баярлалаа. Та нарын дэмжлэг ба МОНЭС-д итгэх итгэл нь бидэнд урам зориг хайрлаж та бидний охид, хүүхдүүдэд сайхан ирээдүйг нь авчрахын төлөө бид ажиллах болно гэдэгтээ эргэлзэхгүй байна.

# GREETINGS

**Dear Friends,**

2010 year has been memorable for all of us! MONES has celebrated her 10th anniversary together with her friends, donors, grantees, partners, volunteers and international sister-funds.

Our celebrations have coincided with the 7th Biennial Sharing and Learning Meeting of the International Network of Women's Funds (INWF) where total of 42 representatives from 32 funds have come to Ulaanbaatar. They have learned about Mongolian women's development and progress, and also have shared their experience and knowledge with us. It was an honour to host an INWF meeting in Mongolia.

With 10 years behind we have evaluated our efforts in contributing to Mongolia's development. We have identified our gaps and revised our grant making strategies. It is an exciting experiment for us to be a part of the history of advancement of women's human rights, freedom, development and the achievement of social change in Mongolia.

MONES' grant making strategy focuses on empowerment and leadership skills development of thousands of women for social change.

We have broadened the scope of our capacity building programme in rural areas. Rural women's NGOs have the opportunity to share and learn from their regional peers, without the need to travel to Ulaanbaatar. This significantly boosts the process of capacity building; and creates opportunities for collaboration and joint efforts to bring social change.

We still pay significant attention to employ the strategy of creating networks, collaborations, unions and partnership among organisations that work for women's human rights.

2012 is the election year in Mongolia, so we put emphasis on 2011 to advocate for women's political participation. We will strive to mobilize more resources for the women's organisations that work for political participation in rural areas. And pay attention to sustainability of those organisations.

And now let us share and extend our heartfelt sincere thanks to all our friends for your support and belief in MONES! And without a doubt we will still work to bring a better future to our daughters and children.



**Ш. ЦЭВЭЛМАА**
***Тэргүүн***
***Монгол Улсын Анхны Тэргүүн Хатагтай***

**TSEVELMAA SH.**
***Head of MONES***
***Former 1st Lady of Mongolia***



**Н.ЧИНЧУЛУУН**
Захирал
**CHINCHULUUN.N**
Director

# АГУУЛГА


Мэндчилгээ 2

Сан бүрдүүлэх үйл ажиллагаа 4

2010 онд хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүн 7

Хамтын ажиллагаа 19

МОНЭС-ийн 10 жилийн ой 20

ОУ-ын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээний уулзалт 22

Санхүүгийн тайлан 24

Манай хандивлагчид 27

Манай хамт олон 29

Хэвлэл мэдээлэл 30


# CONTENT


Greetings 2

Fundraising 4

Outcomes of grants made in 2010 7

Grants of 2010 19

MONES networking 20

MONES 10th anniversary 22

INWF meeting in Ulaanbaatar 24

Financial statements 27

Our donors 28

Our team 29

Press and media 30

## САН БҮРДҮҮЛЭЛТ

2010 онд Дэлхийн эмэгтэйчүүдийн сан, Мама Каш, Филиа, Их Британий Элчин сайдын яам, Чаннел сан, ХААН Банкны дэмжлэгтэйгээр байгууллагын тогтвортой ажиллагаа болон хөтөлбөрүүдийг санхүүжүүллээ. Мөн манай байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд Олон Улсын Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ, Эмэгтэйчүүдийн Сангуудын Сүлжээ хувь нэмрээ оруулаа.

Эдгээрийн үр дүнд 2010 онд нийтдээ 172,334,658 төгрөгийн орлого олж 89,5 %-ийг хөтөлбөрийн үйл ажиллагаа, хамтын үйл ажиллагааны хөгжлийг хангахад зарцуулан ажиллалаа.

2010 онд дотоодын сан бүрдүүлэх эх үүсвэрээр нийт 15,826,900 төгрөгийн хөрөнгө босголоо.

### 88 ӨДРИЙН КАМПАНИТ АЖИЛ

*Хүний эрхийн өдрөөс эмэгтэйчүүдийн эрхийн өдөр хүртэл 88 хоног /2009.12.10 2010.03.08/*

МОНЭС-гаас «Охид эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах 88 өдрийн сан бүрдүүлэх аян»-ыг 2005 оноос эхлэн 6 дахь жилдээ зохион байгуулж байна. Энэ аяны үеэр эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийн асуудлыг олон нийтэд танилцуулах уулзалт ярилцлага хийх, хөрөнгө босгох төрөл бүрийн кампанит ажлыг зохион байгуулдаг юм.




2010 онд «Охид эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалъя» уриан доор эмэгтэй жолооч нарын дунд уран жолоодлогын уралдааныг 2010 оны 3-р сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Уралдаанд 12 эмэгтэй жолооч оролцож, энэ үйл ажиллагаанаас нийт 240,000 төгрөг босгосон юм.

Уралдааныг ивээн тэтгэсэн «Шүрт булаг» ХХК. «Леди» төв, UB авто угаалга «Диана роуз» цэцгийн дэлгүүрийн хамт олонд талархалаа илэрхийлж байна.

## FUNDRAISING

In 2010, we have received programme and organisational development support from Mama Cash, Global Fund for Women (USA), Filia Fund for Women (Germany), Channel Foundation (USA), the Embassy of United Kingdom and Khan Bank of Mongolia. Also International Network of Women's Funds (INWF) and Women's Funding Network (WFN) have supported us for the capacity building of our fund.

In total, MONES has raised MNT 172.3 million (approx USD 127.1 thousand), 87.2 percent of which have been distributed as grants to programme implementation and strengthening collaborations and networking.

And from domestic sources we were able to raise MNT 15.8 million (approx USD 11.7 thousand).

### 88 DAYS FUNDRAISING CAMPAIGN

*From International Human Rights Day till International Women's Rights Day 88 Days (10 December, 2009 – 8th march, 2010)*

Every year, since 2005, with a call to «Protect Women and Girls from Sexual Violence» MONES has been organizing 88 days fundraising campaign. During these days MONES organizes fundraising activities for and awareness raising meetings and discussions on women's rights issues.

This year, MONES has organized a driving contest among women drivers. The contest was held on 6th of March and total of 12 people have participated. We were able to raise MNT 240 thousand (approx USD 178).

Our thanks to all from: Shurt Bulag Co., ltd, Lady Center, Diana Flower Shop and UB car wash.





## ФИЛАНТРОПИ СОЁЛЫГ ХӨГЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Монголын Эмэгтэйчүүдийн Сан /МОНЭС/ нь Олон улсын Филантропи өдрийг 8 дахь жилдээ «Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй эхчүүдийг чадваржуулан орлогыг нэмэгдүүлэхэд тусалж хандив өргөцгөөе» гэсэн уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Бид 2010 оны 11-р сарын 15-наас 30-ны хооронд хандивын аяныг өрнүүлэн 2335400 төгрөгийн хөрөнгө босголоо.

Энэ жилийн Филантропи өдрүүдийн нэг онцлог бол бага насны хүүхдүүдийн ФИЛАНТРОПИ соёлын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, идэвхи санаачлагатай, нийгмийн хариуцлагатай ФИЛАНТРОПЧ иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор 10-р сарын 25-наас 11-р сарын 25-ны хооронд 1 сарын уралдааныг Улаанбаатар хотын 4 дүүргийн ерөнхий боловсролын 15 сургуулийн дунд «БИ-ФИЛАНТРОПЧ» аяныг өрнүүлсэн юм.




Энэ хугацаанд сургууль бүрт сайн үйлсийн ээзн «Үйлсээгийн аян»-ыг өрнүүллээ. Аяны хүрээнд сургуулиуд дээр хүүхдүүд өөрсдөө хөрөнгө босгон тусламж хэрэгтэй байгаа үе тэнгийнхэн, анд нөхөд өндөр настанд туслалаа. Энэ уралдааныг зохион байгуулснаар нийт 9000 гаруй хүүхдийн филантропч үзлийн талаарх ойлголт мэдлэг нь нэмэгдсэн






## CULTIVATING PHILANTHROPY CULTURE


www.suragch.com
suragch_com@yahoo.com
Хүнд эд хөрөнгө мөнгөөр тусалж чадахгүй ч гэсэн өөрт байгаа зүйлээр тусалж чадвал
ТЭР ЖИНХЭНЭ САЙН ҮЙЛС
Би-ФИЛАНТРОПЧ
ҮЙЛСЭЭГИЙН АЯН СУРГУУЛИУД ДЭЭР ӨРНӨЛӨӨ
ТА БУСДАД ЗОРЬСОН ЗҮЙЛДЭЭ ХҮРЭХЭД НЬ ЖААХАН Ч ГЭСЭН ТУСЛАВАЛ ТА ӨӨРӨӨ ХҮССЭН БҮХНЭДЭЭ ХҮРЧ ЧАДНА.

MONES has been celebrating International Philanthropy Days for the past 8 years. International Philanthropy days are celebrated from 15th to 30th November each year. All the money that is raised goes to support capacity building of women with multiple disadvantages. This year MNT 2.3 million (little bit over USD 1.7 thousand) were raised.

This year's Philanthropy Day celebrations were special due to a contest «I am a PHILANTHROPIST» organised among elementary school children. The aim of the contest was to increase children's understanding and knowledge of philanthropy; enable them to initiate, organize and participate in philanthropic deeds; and grow up as a responsible citizen.

Contest was organised from 25th October till 25th November and have covered 15 elementary schools' children. Each school has organised a «Sainuils' (Good deed) campaign» a philanthropic activities, such as raising funds and collecting goods for less privileged children, also helping aged and the weak.

With this contest over 9000 children have increased their knowledge about philanthropy and understood the importance of giving.




## БАЙГУУЛЛАГА БА ХУВЬ ХҮМҮҮСИЙН ХАНДИВ

МОНЭС-гаас 2005 оноос эхлэн ХААН Банктай хамтран «Өрх тэргүүлсэн олон хүүхэдтэй эхчүүдийн орлогыг нэмэгдүүлж ядуурлаас гаргая» гэсэн уриан дор хандивын хайрцагаар хандив цуглуулж байна.

ХААН банкны 22 тооцооны төвд байрладаг МОНЭС-ийн хандивын хайрцгаар 2010 онд 1904320 төгрөгийг тус банкаар үйлчлүүлсэн



үйлчлүүлэгчид хандивлажээ. Мөн МОНЭС-гийн үйл ажиллагаат дэмжиж дуттуйгаар нийт 219 хүн 5,128,620 төгрөг, 15 байгууллага 1,865,965 төгрөгийн хандив өргөлөө.

### МОНЭС-ийн хүндэт хандивлагч

С.Төгс-Оюун олон жил уран бүтээлдээ үнэнч яваа манай цөөхөн эмэгтэй зураачдын нэг бөгөөд МОНЭС-ийн УЗГишүүн эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө өөрийн цаг заваа зориулж байдаг Филантропич юм. Өөрийн орлогын тодорхой хувийг МОНЭС-д байнга хандивладаг ба 2010 онд хувиасаа 359,400 төгрөг давхардсан тоогоор 25 хүнээс 290,000 төгрөгний хандив цуглуулж өглөө.

### МОНЭС-ийн хүндэт гадаадын хандивлагчид

ХБНГУ-ын нэрт ховсчдогч Манфред Кноке өөрийн «Ховсдолын шоу» тоглолтын орлогоосоо 500,000 төгрөгийн хандивыг МОНЭС-д өргөлөө.



Олон Улсын Эмэгтэйчүүдийн сангийн сүлжээний хуралд оролцсон сүлжээний гишүүн байгууллагын төлөөлөгчид нийт 743,600 төгрөгийн хандив өргөлөө.

***МОНЭС-ийн хүндэт хандивлагчиддаа талархал илэрхийлье.***

## DONATIONS FROM ORGANISATIONS AND INDIVIDUAL DONORS

Since 2005 MONES has raised funds through donation boxes placed in 22 branches of Khan Bank. Funds are raised and spent under the call to «Help single mothers with many children increase their incomes and alleviate poverty».

In 2010 MONES has raised MNT 1.9 million (little over USD 1.4 thousand) through our donation boxes, through envelops - MNT 5.1 million (approx USD 3.8 thousand) from individuals and MNT 1.9 million (approx USD 1.4 thousand) from organisations.

### MONES respected donors

Ms. Tugs-Oyun S. one of a few women-artist of Mongolia. She is also a member of the board of MONES and constantly raises funds for the women's cause. She donates a certain amount of her income to MONES and in 2010 she has donated MNT 359.4 thousand from herself and MNT 290 thousand from other individuals, her donations totalled to MNT 649.4 thousand (USD 480).

Mr. Manfred Knoke from Germany has organized «Hypno power» show in Ulaanbaatar in September. From his income he has donated MNT 500 thousand (USD 370) to MONES.

Our sister funds, who have been attending INWF 7th Biennial Sharing and Learning Meeting in Ulaanbaatar have donated MNT 743.6 thousand (USD 550).

Our sincere gratitude to all our donors and supporters!







# ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

МОНЭС 2010 онд 67,7 сая төгрөгийн санхүүжилтийг эмэгтэйчүүдийн 25 байгууллага, бүлэгт олгосон байна. Бид эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудтай удаан хугацаанд тогтвортой хамтран ажилласнаар эмэгтэйчүүдийн амьдралд өөрчлөлт авчирна гэж үздэг билээ. Иймээс олон жилийн хугацаанд хамтран ажилласан эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, ЭТББ-уудын хамтран ажиллах чиглэлээр хуримтуулсан арга туршлагыг нь түгээн дэлгэрүүлэх орон нутгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаар хөгжүүлж, үйл ажиллагаар нь шинэ шатанд гаргахад дэмжлэг үзүүллээ.

## 2010 ОНД ХЭРЭГЖСЭН ТӨСЛҮҮДИЙН ҮР ДҮН

### 1. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ЯЛГАВАРЛАЛЫГ БАГАСГАХ

***Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд Хамтарсан багаар ажиллах арга зүйг хөгжүүлэх***

Дорнод, Хэнтий, Увс, Говь-Алтай, Завхан аймгуудад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд орон нутгийн эмэгтэйчүүдийн ТББ-уудын сүлжээний оролцоог нэмэгдүүлэхийг зорьж ажиллалаа.




Увс аймгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хийсэн судалгааны дүгнэлтэд «...судалгаанд хамрагдагсдын 13.9% нь гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөө гишүүнээ эрхшээлдээ оруулдаг, 23.5% нь гэр бүлийн хүчирхийллийн ямар нэгэн хэлбэр байна гэж хариулсан нь Монгол улсад 5 гэр бүлийн нэг нь хүчирхийллийн харилцаатай, 3 эмэгтэйн нэг нь ямар нэгэн хүчирхийлэлд өртдөг гэсэн 1998 оны судалгааны дүгнэлттэй дүйцэж байна. Иймээс ГБХ-ийн асуудал нь нийгмийн тулгамдсан асуудал хэвээр байсаар байгааг харуулж байна» гэжээ.

Увс аймагт эмэгтэйчүүдийн чиглэлээр ажиллаж байгаа 8 ЭТТБ-ууд нэгдэн, сүлжээгээр хамтран ажиллаж байна. Сүлжээнд нэгдсэн байгууллагууд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах өдөрлөг, уулзалтууд, ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажил зохион байгуулан ГБХ-ийн талаарх иргэд, олон нийтийн



# GRANTMAKING PROGRAM

In 2010 MONES has disbursed MNT 67.7 million to 25 women's organisations and groups. MONES believes that having a long lasting partnership with women's groups brings the change in women's lives. Therefore, we have paid significant attention to building alliances among rural women's organisations; capacity building and sharing experiences of our grantee organisation and groups; and also, to duplicate best practices and experiences of women's organisations and groups.

## OUTCOMES OF GRANTS MADE IN 2010

### 1. ELIMINATING GENDER BASED DISCRIMINATION AND VIOLENCE

***Work methodology of multi-disciplinary team in ensuring the realisation of the Law on domestic violence***

We have worked on ensuring the collaboration and participation of WNGOs in realization of domestic violence law in Dornod, Khentii, Uvs, Gobi-Altai and Zavkhan provinces.



The study conducted in Uvs province showed that 13.9 percent of participants have reported that one of the family partners is domineering over the other; 23.5 percent - live with one or more types of domestic violence. Resulting from this we can see that 1 out 5 families have violent relations and 1 out of 3 women is subjected to violence. The results have not change from the study results made in 1998. Domestic violence is still a pressing issue in Mongolian society.

8 WNGOs of Uvs province have established a network to tackle women's pressing issues. The network have organised campaigns to increase awareness of general public and government about domestic violence situation and preventive measures; they have also educated public about the Law. In Ulaangom and Bukhmurun towns multi-disciplinary teams were established under governor's directive. With the participation of WNGOs counselling services for the victims of domestic violence were established in the province. Also, a portion of a local budget allocated for the prevention of crime programs were set to cover costs of the work on realisation of the Law on Prohibition of Domestic Violence.

ойлголтыг нэмэгдүүлж, төрийн байгууллагуудын идэвхитэй оролцоотойгоор ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг эхлүүлжээ. Улаангом болон Бөхмөрөн сумын Засаг даргын захирамжаар багуудад Хамтарсан баг байгуулан ажиллаж байна.

ЭТББ-удын оролцоотойгоор Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг Хамгаалах байрны үйлчилгээг орон нутагт бий болголоо. Мөн орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зардлыг тусгуулж чадсан байна.

Багануур дүүргийн ХЭҮТ-ийн салбар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын кейсийг Хамтарсан багаар шийдвэрлүүлэхэд нөлөөлж, энэ хугацаанд нийт 3 эмэгтэйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэжээ. Дүүргийн хэмжээнд гэр бүл салалтын шалтгааныг судлан «гэр бүл салалтын нэг шалтгаан бол гэр бүлийн хүчирхийллийн асуудал» гэдгийг тогтоожээ. Багануур дүүргийн шүүхээр гэр бүл цуцлахтай холбоотой асуудал шийдвэрлүүлсэн 173 иргэний хэрэг дээр судалгаа хийж үзэхэд гэр бүл салалтын шалтгааны 52,8 хувийг «хүчирхийлэл, архидалт байнгын хэрүүл маргаан ээлж байна» гэсэн дүгнэлт хийжээ. Мөн гэр бүлээ цуцлуулагсдын дотор гэр бүлийн хүчирхийллийн улмаас 15 эмэгтэй бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл авч байсныг судлан тогтоож, гэр бүлтэй ажиллах, гэр бүлд үзүүлэх үйлчилгээг орон нутагт бий болгоход эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд хамтран ажиллах хэрэгтэй гэсэн асуудал дээр санал нэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, Хамтарсан багаар ажиллах арга зүйг хөгжүүлэх зорилгоор «ГБХ-тэй тэмцэхэд Хамтарсан багаар ажиллах арга зүй» гарын авлагыг Улаанбаатар хотын зарим дүүрэг, Говь-Алтай, Завхан, Увс, Дорнод, Сүхбаатар Хэнтий аймгийн Хамтарсан багаар ажиллаж байгаа 500 гаруй гишүүдэд түгээлээ.

***Ажлын байран дахь бэлгийн дарамтлалтай тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх нь***



МОНЭС-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хийсэн «Ажлын байран дахь бэлгийн дарамтлал Монгол улсад» судалгаа нь манай улсад ажлын байранд бэлгийн дарамт түгээмэл үйлдэгдэж байгаа хэдий ч хохирогчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй байна гэсэн дүгнэлт хийсэн юм.



National Centre against Violence Baganuur district branch staff together with the multi-disciplinary team has helped resolve cases of three women-victims of domestic violence. Domestic violence is one of the main reasons families fall apart. Out of 173 divorce cases in Baganuur district more than half of them (52.8 percent) reported violence, alcoholism and constant arguing as the reasons. Also, 15 women have suffered light to medium damages inflicted to their bodies by their partners. Therefore, WNGOs have agreed on unifying their efforts to work with families on the issue and also, establish counselling and protection services to victims.

With the aim to improve collaboration among NGOs and government agencies in tackling domestic violence issues, and also to improve the collaboration and operations of multi-disciplinary teams we have developed and distributed a manual on methodologies of the multi-disciplinary team. This manual was published and distributed to districts of the capital city and to rural areas, such as Zavkhan, Gobi-Altai, Uvs, Dornod, Sukhbaatar and Khentii provinces, in total, to over 500 women's organisations and groups.

***Improving legal environment to resolve sexual harassment on workplace***



A research was conducted on the situation of sexual harassment on workplace in Mongolia. This study showed that although violations have rather usual occurances in today's Mongolia, protection and legal services for the victims are in a very poor state. This is due to absence of a specific law on sexual harassment on workplace, there are no specific regulations that regulate the labour relations; no clauses of prohibition in by-laws and constitutes of organisations, no any preventive measures stated. There are no any preventive and protection measures put in place in case of such violation occur in any national organisation.

Therefore, the coalition of 17 NGOs, that works on this issue, have first set a goal on to improve legal environment to resolve these issues. They have advocated for the inclusion of specific clauses in organisational by-laws and constituencies, and to create a better environment to prevent and in case necessary to protect the victims. With this aim, coalition have organised trainings for the higher management of 20 organisations, including people working in HR, legal, labour safety and health care departments. In overall, the results of the training were promising. Higher management of organisations have adopted clauses and regulations on prevention of sexual harassment on workplace and protection of victims.

Судалгааны дүгнэлт нь энэ харилцааг зохицуулах бие даасан хууль байхгүй, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан гол хуулиудад ажлын байран дахь бэлгийн дарамтыг бүхий л түвшинд хориглох урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гомдлыг хянах механизм, түүний мөрөөр ажиллах журам зэргийг тусгаж өгөөгүй байгааг харууллаа. Мөн ажлын байранд, хөдөлмөрийн харилцаанд ажлын байран дахь бэлгийн дарамтаас ангид байх, хамгаалагдах боломж бага байна гэдгийг баримтаар нотлосон юм.

Иймд АББД-тай тэмцэх эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын эвслийн гишүүн байгууллагууд өмчийн бүх хэлбэрийн ажил олгогчид болон тэдгээр байгууллага, нэгжид ажиллаж байгаа ажилтны хоорондын харилцааг зохицуулах байгууллагын Дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ зэрэг гол баримт бичигт ажлын байран дахь бэлгийн дарамтаас хамгаалах асуудлыг хуульчилж өгөх шаардлагатай байна гэж тодорхойлсон юм. Энэ зорилгоор эвслийн гишүүн байгууллагуудын нөлөөллийн баг 20 байгууллагын хүний нөөцийн менежер, хуулийн мэргэжилтэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хариуцсан ажилтнуудад Ажлын байран дахь бэлгийн дарамтлалаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудлаар сургалт хийсэн юм. Сургалтын үр дүнд байгууллагуудын Дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, Хамтын гэрээнд АББД-аас ажилтныг хамгаалах заалтуудыг нэмж оруулах асуудлаар байгууллагуудын удирдлагуудтай зөвшилцлөө.АББД-д өртсөн тохиолдолд хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх боломж нөхцөл туйлын хязгаарлагдмал байгаа талаар эвслийн гишүүн байгууллагууд МҮЭХ-ны хуулийн ажлын хэсгийн гишүүдтэй хэлэлцэн, холбогдох хуулиудад нэмэлт оруулах талаар хамтран ажиллах шийдэлд хүрсэн байна.

АББД-ын талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор «Ажлын байрны бэлгийн дарамтлалын эсрэг хамтдаа» уулзалтыг 15 сэтгүүлчдэд хийлээ. Уулзалтын үр дүнд «Монгол», «SBN», C1 телевизээр АББД-аас урьдчилан сэргийлэх асуудлыг хөндсөн тусгай нэвтрүүлгүүдийг олон нийтэд түгээж, FM радиогоор цуврал ярилцлага, мэдээлэл бэлтгэн хүргэсэн.

МОНЭС-гийн дэргэдэх Залуу лидер эмэгтэйчүүдийн клубын гишүүд АББД-ын асуудлаар залуучууд, охид эмэгтэйчүүдийн ойлголтыг нэмэгдүүлэх 6 удаагийн цуврал мэдээллийг бэлтгэн цахим хуудсаар давхардсан тоогоор 5000 гаруй залуучуудадтүгээлээ. Клубын гишүүд төрийн бус байгууллагуудтай хамтран 3 дахь жилдээ зохион байгуулж байгаа Хүний эрхийн парадын үеэр «Бэлгийн дарамтгүй боловсролын орчин» асуудлаар сурталчилгаа хийж, нийт 500 гаруй хүний ойлголтыг нэмэгдүүлж чадлаа. Мөн их дээд сургуулиудын оюутан залуучуудад зориулан өдөрлөг зохион байгуулж, 700 гаруй залуучуудын АББД-ын асуудлын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд нөлөөллөө.

АББД–ын асуудлаар олон нийтэд ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор «Ажлын байр, боловсрол сургалтын орчин дахь БЭЛГИЙН ДАРАМТЛАЛ ба түүнээс сэргийлэх нь» мөн «Ажлын байран дахь бэлгийн дарамтанд өртвөл хуулийн хүрээнд хэрхэн шийдвэрлүүлэх боломжтой бэ?» гарын авлагыг нийт 2,500 хүнд түгээсэн юм.

With the limited opportunity to legally protect victims of sexual harassment, coalition members have conducted an agreement with Labour Unions on advocacy and lobbying activities of policy-makers to amend and include clauses on sexual harassment on workplace into related laws and regulations.

To raise awareness of this issue a meeting called «Together against Sexual harassment on Workplace» was organised for 15 journalists. Meetings and debates were broadcasted over Mongol TV, SBN and C1 TV channels and radio channels hosted interviews with coalition members on this issue.

Young Women Leaders Club girls, a club affiliated to MONES, have raised awareness of adolescent population, spreading 5000 online information leaflets and organising debate meetings. Together with other young activist people they have participated in a Freedom Parade, organised for the third year, in the capital city. They have raised awareness of over 500 people under the call «Education Environment Free from Sexual Harassment». They have organised events for students and have reached out to over 700 of them.

Over 2,500 copies of «Sexual harassment on workplace and in educational environment and its prevention» and also «If you need legal help to resolve sexual harassment on work place» manuals were distributed to public.



## 2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

*Манай орны нийт хөдөлмөрлөж байгаа нийт хүн амын 51.5 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг боловч хууль санаачлах боловсруулах тогтоох болон хууль хэрэгжүүлэх,гүйцэтгэх засаглалын дээд болон дунд түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байна. 21 аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт 698 төлөөлөгчдийн 99 эмэгтэй буюу 14,2 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байна.*

Баруун болон зүүн бүсийн аймгуудын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох зорилгоор Говь-Алтай, Дорнод, Дундговь, Хэнтий, Сүхбаатар, Увс аймаг, Багануур дүүргийн ЭТББ-ууд орон нутгийнхаа эмэгтэйчүүдийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хамтран ажиллах чиглэлүүдийг тодорхойлсон юм. Нэн тэргүүнд анхаарч ажиллах нэг асуудал бол шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж үзсэн байна.Тэд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн тоо цөөн байгаа шалтгааныг тодорхойлохдоо:

- *Удирдах болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийг дэмжсэн тодорхой бодлого байхгүй.*
- *Жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг зохион байгуулахад эмэгтэйчүүд манлайлах үүрэг гүйцэтгэж тэр бүр чадахгүй байна*
- *Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийгээ хэрхэн дэмжихээ сайн мэддэггүй.*
- *Олон нийт эмэгтэй хүнийг эрэгтэй хүнийг хүлээн зөвшөөрдөг хэмжээнд хүлээн авахгүй, эмэгтэйчүүдэд «бид эрчүүдээс чадвараараа дутуу» гэсэн ойлголт хандлага түгээмэл байна.*
- *Эмэгтэйчүүдэд улс төрийн туршлага дутмаг, нэр дэвших болон сонгуулийн сурталчилгааны ажилд шаардлагатай хөрөнгө мөнгө багатай учраас улс төрд ордоггүй, нам доторх эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг дэвшүүлэх сонирхолгүй гэсэн дүгнэлтийг хийжээ.*



Шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Дундговь, Увс аймаг, Багануур дүүрэгт шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийг судлах, тэднийг чадваржуулах чиглэлээ тодорхойллоо.



## 2. INCREASING WOMEN'S PARTICIPATION

Although women comprise 51.5 percent of overall Mongolian population, women's representation in higher decision-making and policy-making levels is very low. Out of 698 representatives of khurals (parliaments) of all 21 provinces, 99 are women, making it 14.2 percent. Out of 135 countries Mongolia is on the 128th (with 3.9 percent participation in National Parliament) place in world classification.

To promote collaboration and strengthening networking WNGOs of Gobi-Altai, Dornod, Dundgobi, Khentii and Sukhbaatar provinces collaboratively have conducted situational analysis on women's issues in their respective provinces. And have developed their collaborative action plans according to the findings of their studies. One of the priorities was the need to work on increasing women's participation and representation in decision- and policy-making levels. WNGOs have identified number of reasons obstructing women's participation:

- *Lack of special mechanisms and policies that support women's participation in decision- and policy-making levels*
- *Women lack leadership skills in organizing gender equality activities*
- *Women do not know how to support each other*
- *Women think they «do not have the capacities as med do» and are only good enough for supporting or second roles*
- *Women lack experience in politics, organizing elections and campaigns, lack financial resources. Men from same political parties do not have the interest in supporting women colleagues.*



We have organized number of trainings and meetings to develop and strengthen collaboration among women already in decision- and policy-making levels and women's NGOs in Gobi-Altai, Dornod, Sukhbaatar, Khentii, Dundgobi, Uvs provinces and Baganuuur district. Also we have worked on finding new leader women and increase their leadership skills.

### *Баруун бүсийн аймгуудын «Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүд болон ЭТББ-уудын хамтын ажиллагаа» зөвлөлдөх уулзалт*

2008 оны орон нутгийн сонгуулиар Завхан аймгийн сумын ИТХ-д 250 эмэгтэй нэр дэвшиж, 127 эмэгтэй сонгогдож, аймгийн ИТХ-д нэр дэвшсэн 20 эмэгтэйгээс 9 нь сонгогдож, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 29,6 хувийг эмэгтэйчүүд эзлэх болсон юм

Завхан аймгийн ЭТББ-уудын сүлжээнийхэн шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдтэй хэрхэн хамтран ажиллаж байгаа туршлагаа Говь-Алтай, Увс аймгийн ЭТББ-ууд болон шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдтэй хуваалцаж, зөвлөлдөх уулзалт зохион байгууллаа. Завхан аймгийн шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүд өнөөгийн түвшинд хүрсэн амжилтаа *«Аймаг сумын хуралд эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэхдээ эмэгтэйчүүд бие биетэйгээ өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж,хэн хаана дэвших гэж байгаа талаарх мэдээллийг олж авч зохицуулж чадсан нь бидний амжилтын гол үндэс болсон юм. Нэр дэвшигчийнхээ давуу талыг нийт сонгогчдод сурталчилж,ойлгуулж чадсан. Нэр дэвшигч эмэгтэйчүүдийн улс төрийн идэвхи нэмэгдэж, өөрсдийгөө хөгжүүлэх санаачлага сонирхол дээшилсэн, зорилгынхоо төлөө тууштай зүтгэж, үүрэг хүлээж биелүүлсэн»* гэж дүгнэсэн юм. Завхан аймгийн ЭТББ-ын сүлжээний санаачлан боловсруулсан «Орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо 2010 - 2012» бодлогын баримт бичгийг аймгийнхаа ИТХ-аар баталгаажуулан ажиллаж байна.

Зөвлөлдөх уулзалтын үеэр эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлаар санал бодлоо солилцох, шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт хийх, ШГТЭО-ны асуудлаар аймаг болон бүсээрээ хамтарч ажиллах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойллоо.

Уулзалтаас лидер эмэгтэйчүүдийг нэгтгэх, тэдэнтэй хамтран ажиллах, улс төрч, удирдагч эмэгтэйчүүдийн туршлагаас нь суралцах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр бүсээрээ хамтран ажиллаж, 2012 оны сонгуульд эмэгтэйчүүдийг бэлтгэх, чадваржуулахад ЭТББ-дын ажиллах чиглэлийг гаргалаа.





### *Regional Forum: Collaboration of women in decision- and policy-making levels and WNGOs of western region*




127 women out of 250 have been elected to Soum Civil Khural in 2008 elections. Out of 20 seats in Provincial Civil Khural – 9 women were elected, comprising 29.6 percent.

Zavkhan province NGO network has organized a consultative meeting with WNGOs of Gobi-Altai and Uvs provinces with the aim to share their experience and build alliance with neighbouring province WNGOs. Women elected to Civil Khurals have shared their success: «Women should not compete with each other, but share information about their constituencies and collaborate. We were able to promote good sides of women running for elections and, therefore, encouraged and have increased candidates' interest and will to serve their purpose». Zavkhan province network has developed a policy - «Women's part in Rural Development 2010 – 2012» (which later was adopted by the Civil Khural) and is working according to it.

During the meeting women have discussed most pressing issues in women's lives; also, evaluated collaboration of women working in decision- and policy-making levels; and have discussed possibilities to work in alliance with neighboring provinces.

Meeting outcome is an action plan leading to increased collaboration among women in tackling pressing issues; collaboration on improving voter's education; collaboration on capacity building and leadership skills building of women-leaders; and collaboration on increasing women's political participation with 2012 elections.

### *Манлайлагч эмэгтэйчүүдийн бүлэг ажиллаж эхэллээ*

Шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийг чадваржуулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Дорнод аймагт эмэгтэйчүүдийн ТББ-уудын сүлжээний хамтран ажиллах чиглэлийн хүрээнд 2011 оныг «Эмэгтэйчүүдийн манлайлал»-ыг нэмэгдүүлэх жил болгон, 2012 оны сонгуулиар аймаг сумын хуралд эмэгтэйчүүдийн төлөөллийг 30-аас доошгүй хувьд хүргэх зорилго тавин ажиллаж эхэлжээ. Манлайлагч эмэгтэйчүүдийн бүлэг нь 2011-2012 онд орон нутгийн ЭТББ-уудын сүлжээний байгууллагуудтай хамтран шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг сайжруулах, орлого нэмэгдүүлэх байгаль орчноо хамгаалах чиглэлээр хамтран ажиллахаар шийдвэрлэсэн байна.

### *Залуу эмэгтэйчүүдийн клубууд орон нутагт ажиллаж байна*

Говь-Алтай, Завхан, Дорнод, Хэнтий аймаг, Багануур дүүргийн ЭТББ-ууд залуу эмэгтэйчүүдийг хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар чадваржуулж, үйл ажиллагаандаа татан оролцуулж эхэлсэн байна. Багануур дүүрэгт Залуу лидер эмэгтэйчүүдийн клуб байгуулж 10 залуу эмэгтэй үе тэнгийнхнийхээ хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх ойлголтуудыг нэмэгдүүллээ.





### *Team of women-leaders have started their work*

A team comprising of 50 women from women's NGOs in Dornod province, «Social Democracy» Mongolian Women's Union, union of Democrat Women have been established with the aim to build capacity of women in leadership position and increase collaboration among them.

Rural WNGOs have proclaimed the year of 2011 - «Women's Leadership Year» and have directed their collaborative operations to increasing women's representation not less 30 percent. Besides increasing women's political participation, women's team is also, working on eliminating violence against women and children; increasing women's incomes and economical empowerment and protection of the environment.

### *Young Women-Leader Clubs are working in Rural Areas*

WNGOs of Gobi-Altai, Zavkhan, Dornod, Khentii provinces and of Baganuur district have established clubs for young women and girls, building their capacity in human rights, gender equality and women's human rights and increasing their activism. Baganuur district club have started their operations with 10 young women, these women are training future girl-trainers in women's human rights and eliminating gender based violence.



## 3. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ БЭХЖҮҮЛЭХ

### *«Эмэгтэйчүүдийн нүдээр» чуулган*




Монголын Эмэгтэйчүүдийн Сан 2005 оноос эхлэн жил бүрийн 3-р сард эмэгтэйчүүдийн өмнө тулгамдсан асуудлыг хэлэлцэх эмэгтэйчүүдийн дуу хоолойг олон нийт болон шийдвэр гаргагчдад хүргэх зорилгоор «Эмэгтэйчүүдийн нүдээр» Чуулганыг 5 дахь жилдээ санхүүжүүлсэн юм. Энэ удаагийн Чуулган нь Үндсэн хуулийн хэрэгжилт Монгол улсад ямар байгааг улс төр, эдийн засагтай холбон авч хэлэлцсэн юм.

Чуулган дээр анх удаа залуу эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонссон нь эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчдийн эгнээг залуу эмэгтэйчүүдээр өргөжүүлэх шаардлагатай байгааг харууллаа.

Чуулганы нэг гол онцлог бол бичил уурхай, хөдөөгийн эмэгтэйчүүд үндэсний болон бэлгийн цөөнхийн эрхийн хамгаалалтын асуудлыг хөндөж дээрх бүлгийн эрх нь хэрхэн зөрчигдөж байгаа тухай асуудлыг эмэгтэйчүүдээр хэлэлцүүлсэн явдал юм.

Чуулганы шийдвэрүүдэд анхаарал хандуулахаа Ерөнхийлөгчийн хүний эрх, иргэний эрхийн бодлогын зөвлөх Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон УИХ-ын 1 гишүүн илэрхийлсэн юм.

Эмэгтэйчүүдийн дуу хоолойг олон нийтэд хүргэхэд МОНЭС анхаарч дангаараа санхүүжүүлдэг байсан бол 2010 оны Чуулганыг Швейцарийн Хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Азийн сан зэрэг байгууллагууд хамтран санхүүжүүллээ.

### *Зүүн болон баруун бүсийн аймгуудын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх*

Эмэгтэйчүүд хамтран ажилласнаар үйл ажиллагааны хүртээмж нэмэгдэхийн хамт эмэгтэйчүүдийнхээ амьдралд өөрчлөлт авчирна гэж үзэн 2010 онд зүүн болон баруун бүсийн аймгуудын Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа дэмжиж ажиллалаа. «Эмэгтэйчүүдийн нөхцөл байдал»–ын дүн шинжилгээнд тулгуурлан орон нутагт ажиллаж байгаа ЭТББ-уудад дараах асуудал тулгамдаж байна гэж үзжээ. Үүнд:



## 3. FOSTERING WOMEN'S MOVEMENT

### *«Through Women's Eyes» National Forum*



Since 2005 MONES has been supporting this forum for the 5th consequent year. This forum organised in March and has a purpose of brining women's voice to policy-makers and general public. The aim of this year's forum was to evaluate the realisation of economic and political rights of women in Mongolia according to Mongolian National Code of Laws.

For the first time in the history of the Forum young women and girls have voiced their pressing issues and have pointed out the need of extending the human rights activists' rows with young people.

Another special side of this forum was that much attention was paid to artisanal mining, rural women, sexual minority have also voiced violations of their rights. WNGOs have come to an agreement that these issues have to be addressed.

Positive feedbacks and follow-ups on addressing raised issues came from Presidential office Unit of human rights, civil right council, and government implementation agency, and also from one member of National Parliament.

Previously MONES has been the only funder of the Forum, this year's Forum was supported in collaboration of Swiss Development Agency, UNDP and Asia Foundation.

### *Increasing women's NGOs collaboration in Eastern and Western regions of Mongolia*

With the belief in women's collaborative efforts to bring a change MONES have supported collaboration among WNGOs in eastern and western regions of Mongolia. According to a study conducted by each province NGOs, women's NGOs have following challenges:

- *Financial challenge*
- *Shortage of human rights professionals*
- *WNGOs do not know how to address an issue collaboratively.*
- *Overlapping programs that hinder the progress and show poorresults. Lack of networking.*
- *Lack of on time information. Since they lack information, research, publications on women's rights issues, they do not know how on which issue to focus on.*

- *Хөрөнгө санхүүгийн бэрхшээлтэй байдал*
- *Эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар бэлтгэгдсэн хүн дутагдалтай*
- *ЭТББ-ууд хоорондоо харилцан уялдаа холбоотой ажиллаж чаддаггүй. Нэг чиглэлийн ажлыг давхардуулан явуулдаг учир хөрөнгө мөнгө, цаг хугацааны хувьд үр дүн муутай болдог. Хамтын ажиллагаа хөгжөөгүй*
- *Мэдээлэл дутагдалтай, эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийн асуудлаар хийсэн судалгаа,мэдээлэл хомс байсан учир тэд ямар асуудлыг сонгож ажиллах вэ? гэдэг нь тодорхойгүй гэжээ.*

Дээрх бэрхшээлийг даван туулахад эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нь хэрэгтэй гэж үзсэн юм. Энэ зорилгоор Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говь-Алтай аймаг, Багануур дүүргийн ЭТББ-уудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, сүлжээгээр ажиллах чадавхийг нэмэгдүүлэх,туршлага солилцох сургалт аялалыг зохион байгууллаа. Сургалт аялалд ЭТББ-уудын 30 төлөөлөгч оролцож, хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх сүлжээгээр хамтран ажиллаж байгаа хотын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай танилцсан юм. Сургалт аялалын дараа зүүн болон баруун аймгуудын ЭТББ-ууд 2012 он хүртэл хийх үйл ажиллагааны хэтийн чиглэлээ гаргалаа.

Эдгээр аймаг, дүүрэгт эмэгтэйчүүдийн эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх сургалтууд,орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо чуулга уулзалтуудыг зохион байгууулжээ. Мөн орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран ажиллах санал дүгнэлт, өөрсдийн хийх үйл ажиллагааны чиглэлийг танилцуулах уулзалтуудыг зохион байгуулснаар эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудалд орон нутгийн төрийн байгууллага болон эмэгтэйчүүдийнхээ анхаарлыг хандуулж чадсан байна.



WNGOs have come to a consensus that to overcome these challenges they first need to learn to effectively collaborate. To help them realise their goal MONES has organised a study tour for Dornod, Khentii, Sukhbaatar, Gobi-Altai province and Baganuur district WNGOs. Give them opportunity to share their knowledge and experience with each other and build a strong networking alliance. 30 representatives from these WNGOs have attended the training on human rights, women's human rights and network building from WNGOs located in Ulaanbaatar. After the completion of the training rural WNGOs have developed their own collaborative action plan till 2012.

WNGOs have organised trainings and meetings for their local organisations to promote rights based approach and women's participation in rural development. Also they have organised introductory meetings with government agencies, which resulted in collaboration between the two parties on tackling issues women face in their daily lives. For example, in Gobi-Altai province «Equal Opportunity» network has been established, consisting of NGOs and WNGOs. They have held talks with other organisations on collaboratively addressing violence against women and children, increasing women's participation in decision- and policy-making levels.







## 4. ДАВХАР ХАМААРАЛТАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЧАДВАРЖУУЛАХ

МОНЭС нь эмэгтэйчүүдийн өөрсдийн нөөцийг дайчлах идэвхтэй оролцоонд тулгуурлан өөртөө туслах чин хүсэл эрмэлзэлтэй эмэгтэйчүүдийг дэмжихийг зорьж байна. 2010 онд нийт 20 бүлгийн 135 эмэгтэйг чадваржуулахад дэмжлэг үзүүллээ.

Зүүн бүсийн аймгуудын ЭТББ-уудын хийсэн судалгаанаас гарсан нэгдсэн дүгнэлтэд давхар хамааралтай эмэгтэйчүүдэд дараах асуудал тулгамдаж байна гэж тодорхойлжээ. Тухайлбал:

- *Эдийн засаг. Өнөөдөр өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд жижиг бизнес эрхэлж, орлогоо нэмэгдүүлнэ гэдэг нь маш хэцүү асуудал. Тэд амьжиргаагаа дээшлүүлэхийг хүсч төрөл бүрийн сургалтуудад хамрагддаг хэдий ч гарааны хөрөнгө байдаггүй.*
- *Ар гэрийн дэмжлэг муу. Гэр бүлийн гишүүд нь эмэгтэйчүүдийг ойлгон дэмждэггүй. Олсон орлогыг нь үрэх, гэртээ байсангүй гэж царгах зэргээр хандаг.*
- *Боловсрол, өөрийн идэвхи санаачлага сул. Тухайн эмэгтэйгээс өөрөөс нь шалтгаалах хувийн зохион байгуулалтгүй байдал амжилттай ажиллахад нь сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал өөрийн санал санаачлага дутмаг, өөртөө итгэх итгэл сул нь эмэгтэйг амжилттай ажиллахад саад болдог гэсэн байна.*

МОНЭС нь эмэгтэйчүүд хамтран бүлэг болон ажилласнаар чадваржих боломж байна гэдгийг олж харж, эмэгтэйчүүдийн өөртөө туслах бүлгүүдийг байгуулан ажиллахыг дэмжлээ.

### *Өөртөө туслах бүлгүүдийг чадваржуулах*




*Бүлэг болон хөдөлмөрөөрөө нэгдэн ажиллаж байгаа хүмүүсийн хувьд явцын дунд бүлэг задрах, бүлгээс гарах явдал маш их тохиолддог. Иймээс тогтвортой, үр дүнтэй авч явахад дараах асуудлыг анхаарах шаардлагатай юм. Хамгийн гол нь бүлэг сайн дурын үндсэн дээр үүссэн,санал санаачлага зорилго чиглэл нэгтэй, зовлон бэрхшээл ижил хүмүүс нэгдсэн, ажлын дадлага туршлага,ур чадварын хувьд ижил түвшний буюу эсвэл нэг нь нөгөөгөө нөхөхүйц чадвартай байх нь чухал юм.*

Дорнод, Ховд аймаг, Улаанбаатар хотын зарим дүүргийн нийт 20 бүлгийн 135 эмэгтэйг доорх үе шатаар чадваржууллаа.

Эмэгтэйчүүдэд өөрсдөд нь байгаа нөөцөө тооцож сургахаас бүлгийн гишүүдийг чадваржуулж эхэлсэн. Бүлгийн гишүүд бүлгийнхээ



## 4. CAPACITY BUILDING OF WOMEN WITH MULTIPLE DISADVANTAGES

MONES has always been a supporter of women, who is active and willing to work hard to overcome poverty. In 2010 alone 20 groups, totalling of 135 women have received grants to address capacity building and income generation.

According to a study conducted by rural WNGOs women with multiple disadvantages face number of challenges. They are:

- *Economical. For women with multiple disadvantages starting a business and increasing their income is nearly an impossible thing. Although many of them attend skills training, they lack of resources is the biggest disadvantage on the way to start a small scale business.*
- *Lack of support from family. Most of these women are misunderstood and mistreated by their family members.*
- *Lack of education and will power. Most of the times lack of organizational skills have negative effect on women's work. Also, lack of self-confidence and creativity.*

One thing that MONES has recognised in working with these women is that there's a way to help these women to overcome obstacles, and hence, supported women's self-help groups.

### *Capacity building of self-help groups*



There are times when groups fall apart and/or member leaves. That is why significant attention was paid to sustainability of the groups and following factors need to be addressed. First of all, groups must be based on good will, with people of common goals and understandings, common interests and experience backgrounds or with cross-changeable capacities.

MONES has supported the work of 20 groups, comprising of 135 women, located in Dornod, Khovd provinces and some of the districts of Ulaanbaatar. They have paid attention to calculating their own resources. Newly established groups have developed their own internal rules, which helped them maintain order and clear understandings of each others' duties.

After they have fully grasped the knowledge of basic accounting, planning, group operational structure, having a common resource pool, running a partnership business and systematic improvement of their product, they were able to advance in their capacity building programme. It was also, nec-

дүрмийг өөрсдөө боловсруулан баталж,мөрдсөнөөр эхнээсээ үйл ажиллагаа нь дэг журам, цэгцтэй явагдах нөхцлийг бүрдүүлж байна.

Тэд нэн тэргүүнд өрхийн орлого, зарлагаа тооцох, бүлгийн зохион байгуулалтаар ажиллах онцлогоо ойлгох, бүлгийн дундын сан байгуулан хийж байгаа бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах сургалтуудад суралцах, өөрсдийнхөө хийж чадах бизнесээ эхлүүлснээр дараагийн үе шат нь үргэлжилсэн юм. Эмэгтэйчүүдийн бүлгүүдийг чадваржуулахад бүлгүүд хоорондоо туршлагаасаа солилцон, бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Бүлгийн гишүүд бүгд нэг ижил төрлийн бүтээгдэхүүн хийнэ гэдгээсээ илүү хэн ямар зүйлийг хамгийн сайн хийж чадаж байна түүнийгээ хийж байгаа нь зах зээлийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх улмаар орлогоо нэмэгдүүлэх боломж бүрддэг гэдэг нь эмэгтэйчүүдийн үйл ажиллагаа харуулллаа. Бүлгээр ажиллаж эхэлснээр эмэгтэйчүүдийн бие биенийхээ өмнө хүлээх хариуцлага нэмэгдэж,хамтын ажиллагаа нь сайжирсан юм. Бүлгүүдийн эмэгтэйчүүд эргэлтийн мөнгөтэй болж,хаана хэнд хандаж мэдээлэл авахаа мэдэж, бие биенээсээ суралцах болсноор өрхүүд бага ч гэсэн байнгын орлоготой байх боломж бүрджээ.



